



“АКМИ КОНСАЛТИНГ” ХХК-НИЙ
ЗАХИРАЛ Б.ЭРДЭНЭДАВАА ТАНАА

ХӨВСГӨЛ АЙМГИЙН МЭРГЭЖЛИЙН
ХЯНАЛТЫН ГАЗАР
УЛСЫН БАЙЦААГЧИЙН ДҮГНЭЛТ

67123. Хөвсгөл аймаг, Мөрөн сум
Утас: 70384468
www.p-hu@inspection.gov.mn

2020.05.11 № 23-03-015/105

Барилгын зураг төсөл хянасан
тухай

Эрүүл ахуйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3. дахь “Барилга байгууламж барих газрын байршил тогтоох, барилгын зураг төсөл зохиох, барилга барих, ашиглалтад оруулах, өргөтгөх, зориулалтыг нь өөрчлөхөд холбогдох хяналтын байгууллагаар эрүүл ахуйн дүгнэлт гаргуулна.” Заалт, МХЕГ-ын даргын 2017 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн А/164 дугаар тушаалаар батлагдсан “Барилга байгууламж барих газрын байршил тогтоох, барилгын зураг төсөл зохиох, барилга барих, ашиглалтанд оруулах, өргөтгөх, зориулалтыг өөрчлөхөд эрүүл ахуйн хяналт хийх, дүгнэлт гаргах заавар”, МХЕГ-ын даргын баталсан 01/57 тоот удирдамжийг үндэслэн “Акми Консалтинг” ХХК-ны 2020 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 1/34 тоот хүсэлтийн дагуу Ренчинлхүмбэ сумын 6 дугаар багийн төв хэсэг ахмадын байрны хойд талд баригдах соёлын төвийн барилгын ажлын зургийг эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч Ч. Одбаяр 2020 оны 05 дүгээр сарын 11-ний өдөр хүлээн авч хяналт хийв.

Ренчинлхүмбэ сумын Соёлын төвийн байранд 0.9 га газар Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ сумын засаг даргын 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/03 тоот захирамжаар олгогдсон байна.

Аймгийн ерөнхий архитекторын 2020 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн АТД-2020/29 тоот архитектор төлөвлөлтийн даалгавар, эскиз зургийг үндэслэн Барилгын зураг төслийг Хөвсгөл аймгийн ЗДТГазрын захиалгаар “Акми Консалтинг” ХХК-ийн гүйцэтгэсэн ЕГ шифр: АКМИ-06/2020 соёлын төвийн барилгын ажлын зураг байна.

Барилгын инженер геологийн “Хангай-Инж Гео” ХХК-ийн ЗТ16-877/16 шифртэй 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 03 дугаар сарын 01-ний хооронд хийгдсэн геологийн судалгааны дүгнэлтээр хөрсний ус илэрсэн, элсэн болон элсэн чигжээстэй том хэмхдэст хөрстэй, хөрсний хөлдөлтийн гүн 2.2-2.3 метр, ОЖЦ хөрс нь мөсжилт ихтэй, дулааны улиралд гэсэхдээ цэвдэгийн дээрх ус үүсэх нөхцөлтэй, газар хөдлөлтийн 9 баллын бүсэд баригдахаар төлөвлөгдсөн байна.

Соёлын төвийн барилга нь 1 дүгээр давхарт үзэгчдийн танхим, тайз, буфет үйлчилгээний өрөө, хувцасны өрөө, нягтлан бодогчийн өрөө, агуулах, хүлээх танхим, эрхлэгчийн өрөө, ариун цэврийн өрөө, тоглолтын бэлтгэлийн өрөө, 2 дугаар давхар нь коридор, номын сангийн фондын өрөө, уншлагын танхим, номын санчийн өрөө, үзэгчдийн танхим, тайз,

14890959

эрхлэгчийн өрөө, сонирхогчдын клубын өрөө, хөгжмийн өрөө, орон нутаг сурталчлах танхим, зан үйлийн танхим, тоглоомын танхим, ариун цэврийн өрөө төлөвлөгдсөн байна.

Хөвсгөл Эрчим хүч ХХК-иас 2020 оны 01 дугаар сарын 23-ны өдрийн 05/2020 тоот цахилгаан эрчим хүчний техникийн нөхцөл өгөгдсөн.

Усан хангамжийн систем нь зөөврийн байх ба 10 м3 эзэлхүүнтэй ус нөөцлөх сав байна. Хэрэглээний халуун усыг ариун цэврийн өрөөнд агшин зуурын ус халаагч байхаар төлөвлөсөн байна.

Бохир усыг 20 м3 багтаамжтай цооногоор зайлуулахаар төлөвлөсөн байна.

Халаалт дулаан хангамж нь бие даасан нам даралтын зуух байхаар төлөвлөсөн. Тус барилгын халаалтын систем нь мухардмал эргэлттэй, доогуур түгээлттэй, 2 хоолойт систем байх бөгөөд халаах хэрэгсэлд "PURMO" маркийн баруун ба зүүн талын холболтой хавтгайлжин радиатор сонгож, ган хавтгайлжин хажуугаас холболттой халаах хэрэгсэл байхар төлөвлөсөн байна.

Агаар сэлгэлтийн систем нь тус барилгын өлгүүр, буфет, нүүр будагч ба үсний өрөөнүүд, хүүхдийн тоглоомын өрөө, номын фонд, номын сан, орон нутаг сурталчлах танхим, зан үйлийн өрөө, ариун цэврийн өрөөнүүдэд тус бүрд агаар сорох ердийн агаар сэлгэлтийн системтэй, үзэгчдийн танхим, тайзны хэсгүүдээс агаар сорох ба оруулах механик систем байхаар зураг төсөлд тусгаж өгсөн байна.

Зураг төслийг хянаад ДҮГНЭХ НЬ:

Тус барилгын ажлын зураг нь нь Халаалт, агаар сэлгэлт ба кондиционер БНБД 41-01-11, Байгалийн ба зохиомол гэрэлтүүлэг БНБД 23-08-02, Барилга доторхи усан хангамж ариутгах татуурга БНБД 40-05-16, Олон нийт иргэний барилга БНБД 31-03-03 дагуу зурагдсан, эрүүл ахуйн заалтуудыг хангаж байна.

ЭРҮҮЛ АХУЙ ХАЛДВАР ХАМГААЛЛЫН
ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ



Ч. ОДБАЯР